



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.003>

The Current Situation Around Russia-Ukraine War

Batbayar Davaadorj

Researcher, Defense Research Institute of Mongolia, E-mail address: daadgai88@gmail.com

Received: 09 July 2026

Revised: 20 July 2026

Accepted: 23 July 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

International relations are currently undergoing a transition toward a hierarchical, multipolar system centered on the United States, China, and the European Union. The Russia–Ukraine war is only one manifestation of this transition, in which many of the broader changes taking place in the international system are expressed in an intensified form. The war is expected to continue throughout 2026, while subsequent developments are likely to extend to the Caspian Sea region.

The impact of the Russia–Ukraine war on Mongolia's stability and security is increasing over time, creating a real and practical need to forecast its future course, outcomes, and consequences. To assess the future prospects of the war, it is first necessary to examine its causes, preconditions, and internal and external circumstances. This will provide the basic understanding needed to interpret the conflict. By analyzing the development of events and identifying the relationships between them, it will then be possible to determine the potential risks.

Combining this basic understanding with an analysis of ongoing developments will make it possible to identify broader trends and forecast future developments. Assessing short-term opportunities and risks in relation to Mongolia's own circumstances will also help create the conditions necessary to protect the country from possible future threats.

Research conducted in this area suggests that, in the near future, we are likely to face rising food prices and a new global economic system characterized by excessive dependence on certain products. Therefore, it is important to remember that it is within our power not only to prevent these circumstances from becoming more difficult, but also to explore ways of turning them into opportunities.

This article was written on the basis of a review of numerous political and historical documents, as well as many hours of commentary and interviews in which economic and military experts assessed current developments. Drawing on these materials, the author presents a forecast of possible future developments.

Key words: SMO, War, Russian invasion, Ukraine, European union, USA, Sanction, NATO, Turkey, China, Central Asia, Conflict zones, Gas, Petroleum.

Орос-Украины дайны эргэн тойронд

Батбаяр Даваадорж

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэгийн эрдэм шинжилгээний ажилтан,
daadgai88@gmail.com*

ХУРААНГУЙ

Олон улсын харилцаа шатласан тогтолцоотой олон төвт (АНУ, БНХАУ, ЕХ) харилцаанд шилжиж байгаа шилжилтийн үе бөгөөд Орос-Украины дайн нь тус шилжилтийн үеийн олон өөрчлөлтүүдийн хурцадмал хэлбэрээр илэрч байгаа нэг л үзэгдэл ба тус дайн нь 2026 оны турш үргэлжлэх бөгөөд дараагийн үйл явдлууд Каспийн тэнгисийн бүс нутгийг хамрахаар байна.

Орос-Украины дайн нь манай улсын тогтвортой хийгээд аюулгүй байдалд нөлөө үзүүлэх байдал нь хугацаа өнгөрөх тусам нэмэгдэж байгаа нь тус дайны цаашдын өрнөл, үр дүн, нөлөөг урьдчилан таамаглан тооцох бодит хэрэгцээ шаардлагыг бий болгожээ. Дээрх дайны хэтийн төлвийг таамаглан тооцоолохын тулд бид юуны өмнө тус дайны шалтгаан, урьдач нөхцөл, гадаад-дотоод нөхцлүүдийг нягтлан судлах замаар танин мэдэж, ойлгох нь суурь ойлголтыг авчрах ба улмаар үйл явдлын өрнөлийг нэгтгэн дүгнэж харилцан хамаарлыг тодорхойлох нь эрсдлийг тодорхойлох боломжоор хангахаар байна. Ингээд суурь ойлголтыг үйл явдлын өрнөлтэй нэгтгэн чиг хандлагыг таамаглаж чадах хийгээд ойрын ирээдүйн боломж, эрсдлийг өөрийн нөхцөлд хамаатуулан төлөвлөх нь ирээдүйд гарах болзошгүй эрсдлээс хамгаалах нөхцлийг бүрдүүлэхээр байна. Тус чиглэлээр хийсэн судалгааны үр дүнд ойрын ирээдүйд бид хүнсий үнийн өсөлт, хэт хамаарал бүхий бүтээгдэхүүний дэлхийн шинэ эдийн засгийн тогтолцоотой нүүр тулах нь тодорхой болж байна. Иймээс дээрх нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй, харин үүнээс боломж бололцоо гаргах арга замыг эрэлхийлэх нь бидний гарт байгааг санах хэрэгтэй байна.

Энэхүү судалгааг хийхэд эдийн засаг, цэргийн экспертүүдийн олон цагийн цаг үеийг дүгнэсэн үнэлгээ бүхий тайлбарламж, ярилцагууд болон олон тооны улс төр, түүхийн баримт бичгүүдийг судалж, цаашдын хэтийн төлөвийг судлаачийн зүгээс таамаглан тус нийтлэлийг бичсэн.

Түлхүүр үг: Цэргийн тусгай ажиллагаа, дайн, Оросын дайралт, Украин, Европын холбоо, АНУ, Хориг, НАТО, Турк, БНХАУ, Төв Ази, Мөргөлдөөний бүс, Байгалийн хий, Шатахуун.

Оршил

Орос-Украины дайны шалтгаан нөхцөл, түүний явагдаж байгаа хэлбэр, байлдааны талбар, үр дүн, түүний нөлөө нь бусад улс оронд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлж байгаа нь уг дайныг зөвхөн хоёр улсын хооронд болж байгаа дайн гэж харахад учир дутагдалтай болгож байгаа тул холбогдох улс орнуудын түүхэн замналыг эргэн харах, онолын үүднээс харилцан хамаарлыг судлаж, дайны үйл явцыг задлан шинжилж, үр дүн түүний нөлөөг уялдуулан ойлгох нь хамгийн тохиромжтой гэж үзэж байна.

Энэ дайны явагдаж байгаа хэлбэр, арга барил нь ХХI зууны буюу ирээдүйн цэрэг-дайн ажиллагаа, түүний бүтэц бүрэлдэхүүн, техник технологийн цаашдын хэтийн төлөвийг тодорхойлж байгаа нь гол онцлог бөгөөд түүнд ХХ-ХХI зууны шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний үр дүнд бий болсон орчин үеийн, урьд өмнө өргөн хэрэглэгдэж байгаагүй арга барил, зэвсэг техникийн ашиглалт, иргэний дэд бүтцийг цэргийн ажиллагаанд ашиглах байдал түүний эмзэг байдал болон харилцаа холбооны дэвшилтэд орчинд нийгмийн сэтгэлзүйд өргөн цар хүрээтэй нөлөөлөх байдал болон цэргийн стратеги, ажиллагаа болон урлагт томоохон

өөрчлөлтүүдийг нэгэнтээ авчраад байна.

Энэхүү дайн нь цаашлаад дэлхийн худалдаа, эдийн засаг, шинжлэх ухааны салбарт томоохон өөрчлөлтүүдийг хэдийн авчирч, дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн өрсөлдөөнд шинэ чиглэл салбар нэмсэн нь нэг талаар боломж мэт боловч нөгөө талаар улс орнуудын хөгжлийн хэт ялгааг авчрах шинжтэй байгааг хэлмээр байна.

Ингээд энэхүү дайн нь цаашлаад ямар үр дүн авчрах боломжтой хийгээд ямар улс орон, бүс нутагт нөлөөлөх, ирээдүйн бидний амьдралд хэрхэн нөлөөлөх талаас нь судлан, хэтийн төлвийг тодорхойлоход энэхүү нийтлэлийн утга санаа оршино.

Судалгааны арга зүй

Геополитикийн ерөнхий зураглалыг оролцогч, нөлөөлөгч субъектүүдын ашиг сонирхлын шалтгаан, өрнөлийг тодруулан гаргаж, тус дайны оролцогч талуудын зорилго, зорилтуудыг харгалзан дайны явц болон одоогоор гарсан үр дүн түүний нөлөөг нөлөөлөгч субъектүүдийн ашиг сонирхол, боломж нөхцөлт байдалд тулгуурлан дайны онцлог болон хэтийн төлөвийг дүгнэн шинжлэх аргагүйгээр эмхэтгэсэн болно.

Ерөнхий зүйл

Орос-Украины дайн нь хоёр улсын хоорондын асуудлаар хязгаарлагдахгүй хийгээд дайны хэтийн төлөв байдлыг дайны уламжлалт ойлголтын статистик, судалгаагааны аргаар тооцож таамаглах нь учир дутагдалтай ба тус дайнд шууд болон шууд бус оролцогч талуудын ашиг сонирхол, түүний шалтгаан, зорилго болон хэдий дуусаагүй байгаа ч дээрх дайны одоогийн үр дүн, түүний нөлөө глобал орчинтой нягт уялдаа холбоотой байна. XX зууны төгсгөл XXI зууны эхнээс эхэлсэн улс, орнуудын цэрэг улс төрийн бодлогыг задлан шинжилж зорилгыг тодорхойлбол.

Европын холбоо (С.М.Юн б.д.) – хүйтэн дайн дуусмагц шинэ орчин нөхцөлд өөрийн тогтвортой байдал, эдийн засгийг хөгжүүлэх, зах зээлээ тэлэх, бие даах, аюулгүй байдлаа хангах шаардлага хэрэгцээ үүссэний дагуу 1993 оны 6 дугаар сард Копенгаген хотод хуучин социалист блокийн улсуудтай харилцах харилцааны зарчим нөхцөлийг тогтоосон нь Европын холбооны тэлэх эрх зүйн баримт бичиг байжээ. Олон улсын шинэ орчинд шилжсэн, дээр дурдсан нөхцөл байдлын хүрээнд тус холбоо нь тэлэх бодлогыг явуулсан нь түүнтэй нэгдэх сонирхолтой Европын бусад орнуудын ашиг сонирхолтой нийцэж, Европ тивийн дийлэнх улсууд элсэж орсон явдал нь дээрх бодлогын үр дүн байсан ба мөн үр дүнгийн нөлөөгөөр тэлэн хөгжиж буй өөрийн эдийн засгийг тэтгэх, ажиллах хүчний хэрэгцээ шаардлагыг хангахаар (1990 он орчим ХБНГУ Турк улсаас, БНФУ хуучин колони улсуудаас цагаачдыг идэвхтэй хүлээн авч ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэж байсан) хуучин туршлага дээр үндэслэн Хойд Африк, Ойрх Дорнод гаралтай цагаачдыг идэвхтэй хүлээж авсан нь амжилтад хүрсэнгүйгээр барахгүй нийгмийн бүтцийн хямрал хүргэсэн байна. Мөн АНУ-тай хэт их хамааралтай байдлыг багасгах, Турк улсыг хязгаарлах, цаашлаад бие даах, ирээдүйд шинэ зах зээл нээх харилцааг өргөжүүлэхээр Украин болон Гүрж улсуудыг өөрийн эдийн засагт уялдуулах замаар тэлэх бодлого явуулсан нь ОХУ-ын ашиг сонирхолтой зөрчилдсөн байна. Европын холбооны тэлэлтийн суурин дээр НАТО гишүүн бус орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд өөрийн стандартыг нутагшуулж чимээгүй тэлэх бодлого

явсан гэдгийг бас санах нь зөв.

ОХУ – ЗХУ-ын залгамжлагч гэж өөрийгөө тодорхойлсон ОХУ нь иргэний дайн, эдийн засаг, улс төрийн хямрал, гэмт хэргийн нөхцөл хүндэрсэн байдлаас гарах боломжийг ЗХУ-аас үлдсэн зэвсгийн нөөцийг зарж борлуулах түүнийг АНУ-тай хийх гэрээ хэлэлцээрт ашиглах, шинэчлэл шаардсан батлан хамгаалахын аж үйлдвэрийн хэсгийг гадаадын хөрөнгө оруулалтаар иргэний зориулалтын болгон шилжүүлж барааны хомсдолоос гарах, газрын тос, байгалийн хий олзворлох аж үйлдвэрийн салбарыг хувьчлан хувийн хэвшлийн хүч, санхүүжилтээр шинэчлэх, шинэ орд газруудыг эрэн хайж нөөцийг тогтоох, түүнийг ашиглах арга замаар шилжилтийн үеийн хямралыг даван туулжээ.

Улс төрийн сонгуульд ялсан ерөнхийлөгч Путин В.В. нь 2001 онд улс төрийн нам, хөдөлгөөнийг нэгтгэж “Нэгдсэн орос” ([Мудрац 2019](#)) намын суурийг тавьснаар дараагийн сонгуульд өрсөлдөх боломжоо бататгасан байна. Мөн иргэний дайныг дуусгаж улсын төсвийн орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэхээр хувьчлагдсан байсан тогтмол үнийн өсөлттэй салбар болох газрын тос, байгалийн хий олзворлох, боловсруулах аж үйлдвэрийн салбарыг өөрийн ойрын хүмүүсээр удирдуулсан Роснефть, Газпром зэрэг төрийн өмчит компаниудын дор нэгтгэн Европын зах зээлд борлуулах шат дараатай улс төр, эдийн засгийн бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн төдийгүй ОХУ нь хуучин ЗХУ-ын өв залгамжлагч мөн тул түүний эзэмшилд байсан нөлөөний бүсүүд нь өнөөгийн ОХУ-ын ашиг сонирхол, эдийн засгийн бүс мөн хэмээх бодлогыг аажмаар явуулж эхэлсэн байдаг. 2008 онд Өмнөд Осетинд тус бодлого нь хамгийн анхны бодит сорилттой тулгарч Гүрж-Осетины мөргөлдөөнөөр илэрсэн байна. Тус үйл явдлын дараа ОХУ нь “Батлан хамгаалахын шинэчлэл 2008-2020” бодлогыг ([Закончена десятилетка перевооружения 2020](#)) гурван үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.

Энэ цаг үеэс эхлэн ОХУ нь ЗХУ задарсан нь ХХ зууны хамгийн том алдаа хэмээн ярьж эхэлсэн бөгөөд эргээд “хүчний тэнцвэрт” харилцааг сануулж эхэлсэн ба БНХАУ-ын оролцоог тооцон олон төвт дэлхийн шинэ харилцааг мөн идэвхтэйгээр санал болгож байсан байна.

Иймд ЗХУ-ын эдэлж байсан зарим давуу байдлыг ОХУ-д авчрах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь санхүүгийн чадвартай болж байгаа тус улс Беларусь, Украин улсуудын эдийн засгийг өөрийн эдийн засагтай уялдуулж нэгдсэн нэг зах зээлтэй байх зорилго бүхий хөрөнгө оруулах, нэн хөнгөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж олгох, өрийг тэглэх зэргээр хэрэгжүүлсэн байна. Харин барууны улсуудтай улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд эрчим хүчний түүхий эдийг нэн хөнгөлөлттэй үнээр удаан хугацаанд тогтвортой хангах, өөрийн батлан хамгаалахын аж үйлдвэрийн салбарын хэсгийг иргэний салбарт шилжүүлж дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн өөрийн зах зээлд тэдгээр орнуудаас хөрөнгө оруулалтыг татах, ашиг сонирхлыг хангах зэрэг арга хэлбэрээр хэрэгжүүлсэн байна. Харин Төв Азийн улсуудад өөрийн үйлдвэрлэсэн зэвсэг техникийг хөнгөлттэй үнээр нийлүүлэх, засварлах болон тухайн улсын иргэдийг ОХУ-д боловсрол эзэмшүүлэх, өсөн тэлж байгаа өөрийн эдийн засагт ажиллах хүч татах, улс хоорондын хурцадмал асуудлыг зуучлах зэрэг арга хэлбэрээр хэрэгжүүлсэн байна.

ОХУ-ын дээрх бодлогын үр дүнд 2014 он гэхэд ЗХУ-ын нөлөөний бүсийг өөрийн нөлөөнд оруулж Европын зах зээлийн эрчим хүчний түүхий эдийн хангалтын дийлэнх хувийг хангаж байсан нь ОХУ олон улсын тавцанд “Их гүрэн” гэх статусаа бэхжүүлсэн.

Гэсэн хэдий ч нөлөөний бүс гэгдэх бүс нутаг дах улс орнуудаас оросын ашиг сонирхолд үл нийцэх зарим нэг санаачилгууд гарч эхэлсэн. Тухайлбал Украины Ерөнхийлөгч Л.Кучмагийн засаглалын үед буюу 1994-2004 онд нээлттэй гадаад бодлогын чиг хандлагатай нь “Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн байгууллага”-ыг (СНГ) үүсгэн байгуулагч улсуудын нэг гэсэн утгаар хуучин социалист орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хангаж, мөн Европын холбоо болон НАТО-той хамтын ажиллагааг эхлүүлж, өргөжүүлэх чиг хандлагатай байснаар харагддаг. Үүний дараа 2004 онд ерөнхийлөгч В.Ющенкогийн засаглалын үеэс барууны чиг баримжааг тодотгож Европын холбоо болон НАТО-д элсэх хүсэлтийг албан ёсоор гаргаж, дээрх холбоодод элсэх процессыг эхлүүлэхийн зэрэгцээ “Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн байгууллага”-аас гарах хүсэл эрмэлзлэлээ илэрхийлж байсан байна. 2008 онд болсон Гүрж-Өмнөд Осетины мөргөлдөөний үед Гүржийн талд байр сууриа илэрхийлэхийн хамт ОХУ-ын Хар тэнгисийн флотын асуудлыг хөндөж зарим нэг хязгаарлалтуудыг тавьсан нь ОХУ-ын зүгээс Украинд явуулах бодлогыг эрс өөрчлөх эхлэл байсан байна.

Харин 2010 онд В.Янукович ерөнхийлөгч болсноор ОХУ-ын Хар тэнгисийн флотын баазын түрээсийн гэрээг 32(+5) жилээр сунгасан, НАТО-д элсэн орох комиссыг татан буулгаснаар ОХУ-тай харилцаагаа сайжруулж чадсан боловч дотоод улс төрийн асуудлууд хурцадмал байдалд хүрсэн байна. Гэвч ерөнхийлөгч В.Янукович нь Европын холбоонд нэгдэх чиглэлийг дэмжиж байсан бөгөөд нэг талаас ОХУ өөртөө татах бодлогыг хөнгөлөлтэй зээл олгох, байгалийн хийн төлбөр тооцоог хөнгөвчлөх мөн түүнчлэн Евроазийн эдийн засгийн холбооны гаалийн холбоонд нэгдэх саналыг тавьсан явдал нь Европын холбооны зүгээс хатуу шүүмжлэлд өртсөнөөр Евроазийн эдийн засгийн холбооны гаалийн холбоонд ажиглагчаар оролцох, Европын холбооны чиглэлд тус холбоонд элсэн ороход алдагдах хохирлыг мөн холбооноос нөхөн олговор хэлбэрээр авах хүсэлтэйг илэрхийлэн дээрх хоёр чиглэлийн ажлыг зогсоосон байна.

Дээрх шийдэл нь хурцадмал байсан дотоод улс төрийн байдлыг улам хүндрүүлж улмаар ард иргэдийг хуваагдмал байдалтай болгосон нь даамжирсаар, иргэдийн дунд Шенгений улс орнуудад визгүй зорчих боломжийг хаасан мэтээр тархаж, хүчний байгууллага жагсаал цуглааныг хүч хэрэглэн дарсан зэрэг асуудлуудаас болж нийтийг хамарсан эмх замбараагүй үйл явдал болж төр эргэсэн (Евромайдан) байна. Энэ үйл явдлын улмаас ерөнхийлөгч В.Янукович нь ОХУ руу зугтсан нь Крым болон Луганск, Донецк мужуудад Украины төвийн засаглалын эсрэг хүчийг бий болгож улмаар ОХУ-ын тусгай албадын дэмжлэг, хатгаасаар салан тусгаарлах, тусгаар тогтнолоо зарлах байдалд хүргэжээ.

Европын холбооны зах зээлийн бүтэц, болон гэрээний нөхцөлүүд нь Украин улсын аж үйлдвэрийн салбарыг уналтад оруулах байсныг тухайн үед хэн ч сонирхоогүйг болон өрнөөд байсан жагсаал цуглаан нь “Арабын хавар”, “Өнгөт хувьсгал”-ын санагдуулж байсныг энд сануулах нь зүйтэй. Энэ мөчөөс эхлэн Украин улс барууны чиг баримжаагаа шууд илэрхийлж эхэлсэн нь түүнд ОХУ

таагүй хандах, Европын холбоо асуудлыг даамжруулах хандлага бий болсон байна.

Товчхондоо тус улсын тухайн үеийн нөхцөл байдлыг дүгнэвэл улс төрийн тогтворгүй, залгамжгүй бодлогын уршиг, хийгээд нийгэм дэх шударга ёс алдагдсан, авилгийн асуудал урхагшсан суурь нөхцөлд тухайн үеийн ерөнхийлөгч нь хэт өөртөө итгэж, дотоод улс төрийн хямралаа зохицуулж чадаагүй нь ард түмнийг талцалд хүргэж, улмаар чиглэн ирж байгаа хоёр хүчний хооронд тэнцвэрийг бариагүй, түүнчлэн бусад улсын тусгай албадын үйл ажиллагааг хязгаарлаж чадаагүй ба мөн өөрийн байр суурийг тодорхой илэрхийлж ойлгуулаагүй нь одоогийн дайны суурийг тавьсан гэж харж болохоор байна.

Өөрчлөлт

Дээрх нөхцөл байдлын улмаас Украин улсын улс төрийн хямрал, дотоодын үймээн самуун даамжирсантай зэрэгцэн ОХУ 2014 онд Хар тэнгисийн флотоо хадгалж үлдэх, урд талдаа далайд гарцтай болох хийгээд ирээдүйн болзошгүй дайнд стратегийн ашигтай байршил эзлэх, бэлэн байх, Хар тэнгисийн бүсэд өөрийн оролцоог хангах зорилгоор Крымын хойгийг өөртөө нэгтгэсэн. Ингэснээр олон улс дахь өөрийн байр суурийг цэргийн хүчээр бататгах, цаад утгаараа Африк тив болон Ойрх дорнодод нөлөөгөө тэлэх зорилгоор 2015 оноос Сири улсад цэргийн баазаа шинэчлэн сэргээж тус улсын иргэний дайнд тухайн үеийн ерөнхийлөгч Башар Асадыг дэмжин оролцсон зэрэг анх удаа хилийн цаана өргөн хэмжээний цэргийн ажиллагаа явуулсан, барууны орнуудтай хамтарч “Ирак, Левантын Исламын улс”-ыг (ИГИЛ) устгасан нь дэлхий нийтэд ОХУ нь эргэж буцалтгүй их гүрэн болсон мэт ойлголтыг төрүүлсэн байна. Өдөр ирэх тутам өөртөө итгэлтэй болж байгаа ОХУ нь дэлхийн өнцөг булан бүрт ил далд хэлбэрээр бодлогоо хэрэгжүүлсний бодит жишээ нь өдгөө нууц биш болсон хувийн цэргийн компани болох Вагнераар дамжуулж Африк дахь Францын нөлөөний бүсэд өөрчлөлт оруулсан байдал, өөрийн зэвсгийг НАТО-ын гишүүн Турк улсад борлуулсан, гуравдагч (Энэтхэг, Мьянмар) улсуудтай цэргийн хамтын ажиллагааг эрчимжүүлсэн зэргээс харагдаж байна.

Мөн энэ үеэс Украины нөхцөл байдал хурцадмал болж Донецк, Луганск мужууд тусгаар тогтнолоо зарлаж иргэний дайнд татагдан оржээ. Украин улсын зүгээс “Антитеррорын ажиллагаа” гэсэн нэрийдлээр хяналтаа алдсан мужуудад эрх мэдлээ эргүүлэн тогтоохоор цэргийн ажиллагаа явуулсан нь бүтэл муутай болохын зэрэгцээ хэт үндсэрхэг үзэлтэй цэргийн бүлэглэлүүд үүсэж улмаар төвийн засгийн газартай хурцадмал харилцааг үүсгэсэн байна. Нөгөө талаас ОХУ нь далд хэлбэрээр өөрийн цэргийн алба хаагчдыг салан тусгаарласан мужуудын далбаан доор цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцуулсан төдийгүй зэвсэг техник, эд материалын хангалтыг тасралтгүй үзүүлж байв. Улс төрийн хувьд “Минскийн хэлэлцээр” гэсэн нэрийдлийн доор тус цэргийн ажиллагааг орон нутгийн түвшинд барьж, Украин улсыг барууны дэмжлэгээс таслах зэрэг үйл ажиллагааг өөрийн улс төр, эдийн засгийн давуу байдалд тулгуурлан идэвхийлэн явуулсан байна. Дээрх үйл явдлын улмаас Украины улс төр, нийгэм эдийн засгийн байдал уналтад орж 2019 оны сонгуулиар В.Зеленский ерөнхийлөгч болж нийтийг хамарсан шинэчлэлтийг хийж эхэлсэн бөгөөд гадаад бодлогын хувьд дипломат харилцаанд тулгуурласан дэмжлэг авах бодлогыг тун амжилттай хэрэгжүүлсэн байна. Мөн

дотоодод бүх цэргийн болон тусгай албадын үйл ажиллагааг батлан хамгаалах яаманд захируулах зэрэг шинэчлэлийг дайн эхлэхээс өмнө эхлүүлж чадсан байна.

Дээрх цаг үеийн үйл явдалтай давхцан Төв Азийн улсууд болон Өмнөд Кавказын Армен, Гүрж улсуудтай ОХУ-ын харилцах харилцаа тэнцвэргүй тэгш бус, тулгах шинж чанартай болж эхэлсэн нь ОХУ ёс төдий эдийн засгийн хоригт орж эхэлсэн хийгээд эдийн засгийн нөөц, харилцаа холбооны түшиц газрыг өөрийн нөлөөний улсуудад байгуулах шаардлага үүссэн зэрэгт оршиж байжээ. Мөн үйл ажиллагааны хүрээнд ОХУ нь БНХАУ-тай ойртох бодлогыг баримтлахын зэрэгцээ өөрийн нөлөөний улсуудад идэвхтэй хөрөнгө оруулалт хийж эхэлсэн байна. Өмнөд Кавказад Турк улсын ашиг сонирхолтой тулгарснаар 2020 онд “Карабахын дайн” 3 сарын хугацаанд өрнөж Азербайжаны ялалтаар дуусгавар болсон нь “Байрактар” нэртэй нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг бидэнд өргөн хэлбэрээр анх танилцуулсан билээ. Карабахын дайны үр дүн, түүний нөлөөгөөр Өмнөд Кавказын бүс нутаг дахь ОХУ-ын байр суурь суларч эхэлсэн байна.

Энэхүү үйл явдал нь Төв Азийн (Тажикстанаас бусад нь) улс орнуудыг Турк улстай ойртоход түлхэц болсон бөгөөд Турк улс нь Өмнөд Кавказ болон Төв Азийн улсуудад хэрэгжүүлдэг нэг хэл, нэг шашин гэсэн бодлогоо эрчимжүүлсэн байна. Нөгөө талаас Төв Азийн бүс нутагт БНХАУ-ын “Нэг зам, нэг бүс”-ийн бодлого (Е.Ф.Поддубская 2024) эрчимжих тодорхой байр суурийг олж авсан гэдгийг санацгаая.

Хурцадмал байдал

2022 оны 1 дүгээр сард Казахстанд байгалийн хийн үнийн өсөлтөөс үүдсэн эсэргүүцлийн хөдөлгөөн нь даамжирсаар 1991 оноос эхлэлтэй нийгмийн тэгш бус байдлын бугширсан бухимдлаар тэлж нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэв. Тус эмх замбараагүй байдлын эсрэг “Хамтын Аюулгүй байдлын гэрээний байгууллага”-ын (ОДКБ) нэрийн доор ОХУ-ын цэрэг Казахстан улсын онцгой объектуудыг хамгаалах зорилготой хэмээн цэргээ оруулсан нь тухайн үеийн ОХУ-ын зэвсэгт хүчний хөгжсөн байдлыг харуулсан байдаг. Мөн 2021 оны намраас Украин улсын хилийн дагуу Беларусь болон өөрийн нутаг дэвсгэрт цэргийн сургуулилт нэрийн доор цэрэг хуримтлуулж байсан явдал юм.

ОХУ өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, НҮБ-ийн дүрмийн 51-р зүйл болон Донецк, Луганскийн улстай байгуулсан гэрээг үндэслэл болгон орос хэлтэй иргэдийн аймаглан устгаж байгаа байдал, неонацист үзэл санааг устгах, таслан зогсоох шалтгаанаар Украин улсыг цэргийн хүчгүй, нацист үзэл санаагүй, цөмийн зэвсэг үйлдвэрлэх боломжгүй байлгах хэмээн зорилгоо тодорхойлж, ОХУ-ын эх орноо хамгаалагчдын баярын маргааш буюу 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Москвагийн цагаар үүрийн 4-5 цагийн орчимд 180-200 мянга орчим мэргэжлийн цэргийн бүрэлдэхүүн өргөн хэмжээний довтолгоогоор Орос-Украины дайныг ОХУ эхлүүлжээ. Энэ үйл явдлаас 24 цагийн өмнө буюу 23-ны өдөр Украин улс өөрийн зэвсэгт хүчнийг байрлалд шилжүүлсэн байсан нь тухайн улсын цэргийн удирдлага хийгээд АНУ тэргүүтэй барууны улсуудын анхааруулга, сэрэмжлүүлэг, цагийн байдлыг бодитоор үнэлсэн зэрэгт оршино.

Ингээд Крым, Донецк, Курск, Белгород муж, Беларусь улсын нутаг дэвсгэрээс Киев, Херсон, Харьков болон Донецк мужийн чиглэлээр цэргийн давшилтын

ажиллагаа эхэлж 2023 оноос зууралдсан байлдааны ажиллагаа түлхүү болохын хэрээр артиллерийн байлдааны ажиллагаанд үндсэндээ шилжиж фронтын шугам ерөнхийдөө тогтсон байдал ажиглагдсан байна. Энэ хугацаанд дайнд оролцогч талуудад бэлтгэл цэргийн хүчийг сургах, материал техникийн хангалтыг хийх зэрэг ар талын голцуу ажиллагаа нь эдийн засгийн нөөц бололцоог шавхаж байв. Мөн оны зун ид өрнөсөн артиллерийн тулаанд БНАСАУ нь ОХУ-ын артиллерийн сумны хангалтыг хийж байсан нь одоо нэгэнт илт болоод байна. Мөн оны эхний хагасаас хүнд байдалд орсон зэвсэгт хүчнийг дахин бүлэглэх ажиллагааг хийж байлдааны ажиллагаанд бэлдэх зорилгоор Африк тивээс өмнө нь нууж, үгүйсгэж байсан хувийн цэргийн компани болох Вагнерьг татан авчирсан төдийгүй тус компанид хорих ангиудаас цэрэг татах эрхийг олгож олон тооны гэмт хэрэгтнүүдийг ялаас мултрах гарцтай болгожээ.

Дайнаас үүдэлтэй олон улсын хориг арга хэмжээ 2024 оноос нийгэм, эдийн засагт нөлөөгөө үзүүлж эхэлсэн ба ОХУ-с иргэд дүрвэх нь нэмэгдсэн, цэрэг татлагын байдал муудсан зэрэгтэй холбогдуулан өндөр цалин хөлс олгох замаар цэрэг татлагын ажиллагааг эрчимжүүлсэн нь тодорхой хэмжээнд амжилтыг дагуулсан ч эргээд нийгэм-эдийн засгийг хүндрүүлэх туйлдуулах байдалд хүргэх шинжтэй болгосон тул баялгийн сангаас санхүүжилтийг идэвхтэйгээр хийсэн нь түүний ашиглах боломжтой хэсгийг шавхсан явдал юм. Тухайлбал өндөр хөлс бүхий сайн дурын гэрээг ОХУ-ын ядуу хэсэг болох Новосибирскээс зүүн тийш нутгийн иргэд түлхүү ашиглан цэрэгт сайн дураар явсан байна.

Үүнтэй зэрэгцэн Украины арми ОХУ-ын нутаг дэвсгэрт довтлон орж эхэлсэн бөгөөд тус үйлдэл нь байлдааны талбарыг ОХУ-ын нутаг дэвсгэрт шилжүүлэх, улс төрийн байдлыг ганхуулах, Донецк муж дахь төвлөрсөн цэргийн гол хүчийг сарниулах зэрэг олон талтай байсан байна. Гэвч БНАСАУ-ын цэргийн хүчийг өндөр өртөгтэйгөөр ОХУ-ын нутаг дэвсгэрт цэргийн ажиллагаанд оролцуулж Украины зэвсэгт хүчнийг шахан гаргасан байна.

Олон улсын тавцанд дэлхийн улс орнууд Орос-Украины дайнаас үүссэн болон үүсэж болох өөр өөрсдийн ашиг сонирхлын дагуу талцан хуваагдах үзэгдэл эрчимжиж бараг хуваагдаад дууссан бөгөөд ковид-19-ийн дараа сэргэж амжаагүй байсан олон улсын байгууллагуудыг сөхрүүлж амь төдий болгосон байна. Мөн 2024 он нь АНУ-ын сонгуулийн жил байсан тул тус улсын улс төрийн дотоод асуудлуудаас Украины талд үзүүлэх зэвсэг, техникийн хангалтын асуудлууд шууд хамаарч хувьсан өөрчлөгдөж байсан нь Украины талд сөргөөр нөлөөлж, харин ОХУ-ын талд эерэг үр дүнг авчрах төлөвтэй байсан байна.

ОХУ нь дээрх нөхцөл байдлыг ашиглан 2024 онд Донецк мужид цэрэг хуримтлуулж эхэлсэн (170.000-200.000) бөгөөд мөн оны төгсгөлд Д.Трамп ерөнхийлөгчөөр сонгогдсоноор түүний дайныг богино хугацаанд дуусгана гэсэн амлалтад итгэсээр дэлхий нийт оноо үдэв.

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль дуусч, Д.Трамп бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй зэрэгцэн ОХУ нийт фронтын дагуу давшилтыг эхлүүлсэн бөгөөд оны төгсгөлд амжилтад хэсэгчлэн хүрсэн байна. АНУ нь бүх халуун цэгүүд болон хурцадмал асуудалтай газруудад тусгай бүрэн эрхт элчүүдийг томилон бүх дайсагнагч талуудыг хэлэлцээрийн ширээний ард урьсан/шахсан нь нааштай мэт

харагдаж байгаа боловч үнэн хэрэгтээ өөрийн ашиг сонирхлыг тэргүүнд тавьсан байжээ.

2025 он гарснаар Д.Трамп ерөнхийлөгчийн тангараг өргөж бүрэн эрхээ эдэлж эхлэхтэй зэрэгцэн бүс нутгийн түвшинд байсан асуудлууд нийтдээ дэлхийг хамарсан болж хувирчээ. АНУ нь юун түүрүүнд худалдааны тарифын дайныг дэгдээж, халуун цэгүүдийг нэг нэгээр нь онилж тайлбарлахад бэрх улс төрийн ажиллагааг явуулж эхэлсэн гэхэд хилсдэхгүй байх. Өөрийн холбоотон улс, өрсөлдөгч, дайсагнагч гэж үл харгалзан өргөн хэмжээний улс төрийн интервенцийн бодлого явуулсан нь 2025 оны 12 дугаар сард нийтлэгдсэн АНУ-ын “Үндэсний аюулгүй байдлын стратегийн баримт бичиг”-ээр тайлбарлагдсан.

Дүгнэлт

Олон улсын харилцаа нэг туйлт ертөнц буюу АНУ-ын дангаар ноёрхох байдлаас шатлалт тогтолцоотой гурван (АНУ, ЕВРОПЫН ХОЛБОО, БНХАУ) төвт харилцаанд шилжих процессын үе гэж хэлж болохоор байна. Шилжилтийн шинжийг агуулсан өөрчлөлт нь Хар тэнгис (Орос-Украины дайн) – Ойрх Дорнод (Иран)/Өмнөд Кавказ (Гүрж) – Төв Ази (Орос-Казахстан, Тажикстан-Афганистан)/ Афганистан – Ази, Номхон далай гэсэн чиглэл бүхий дараалалтай явагдаж, хурцадмал байдал, хямралын хэв шинжийг агуулахаар байна.

Харин Балтийн тэнгис, Зүүн Хойд Ази болон Грийнланд арал буюу хойд бүсийг ороосон жижиг тойрог нь дээр дурдсан бүс нутгуудыг бодвол харьцангуй тайван буюу түгшүүртэй тайван байдалтай байх хандлага бүхий шинжтэй ба одоогийн өөрчлөлтийн дараа идэвхжих төлөвтэй байна гэж үзэж болохоор байна. Манай хойд хөрш ОХУ-ын стратегийн ашиг сонирхлын цэгүүд тус глобал орчны өөрчлөлт бүхий цэгүүдтэй давхцаж байгаа байдал ажиглагдаж байна.

Иймд Орос-Украины дайн нь тус шилжилтийн үеийн олон өөрчлөлтүүдийн хурцадмал хэлбэрээр илэрч байгаа нэг л үзэгдэл гэж дүгнэж болохоор ба тус дайн нь ХХI зууны дайны хэв шинжийг тодорхойлж байгаагаараа онцлогтой бөгөөд нэг талаас Европын холбооны ашиг сонирхол шингэж Украины тусгаар тогтнолыг хөндсөн, нөгөө талаас ОХУ-ын стратегийн ашиг сонирхлыг хөндсөн хоёр улсын хоорондын зарлагдаагүй дайн байна. Орос-Украины дайныг онцлог болгож байгаа шинэ төрлийн зэвсэг буюу нисгэгчгүй нисэх төхөөрөмж бөгөөд тус шинэ зэвсэг нь байлдааны талбарын үндсэн нөхцөлийг эрс өөрчилсөн ба тус өөрчлөлтийн хүрээнд байлдааны тактик хувьсан өөрчлөгдөж байна.

Байлдааны ажиллагаа ихэвчлэн хот суурийн газарт өрнөж байгаа ба дроныг идэвхтэй ашигласнаар шилэн болгосон явдал нь байлдааны тактикт өмнө өргөн дэлгэр ашиглагддаггүй байсан тусгай бүлгийн объект цэвэрлэх тактикаас урган гарсан жижиг бүлгүүдийн тактикт талууд шилжсэн нь байлдааны стратеги болон оперативын төлөвлөлтөд цаг хугацаа, галын хүч, хөдөлгөөнт байдал болон хамгаалалтын тооцоололд өөрчлөлт оруулснаараа онцлогтой байна.

ОХУ-ын талаас Днепр мөрний зүүн эрэг дэх фронтын шугамыг Запорожье – Купянск дагуу тогтоох Крымын хойгийн усан хангамжийг шийдэх, ар талын тогтвортой байдлыг хангах, Днепр мөрний баруун эрэгт байлдааны талбарыг шилжүүлж операцын орон зайд гарах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байна. Украины талаас Азовын тэнгист хүрч Крымын хойг, Херсон дахь цэргийн

бүлэглэлүүдийг хуурай замын ар талын хангамжаас тасалж улмаар Приднестровийн чиглэлийг идэвхгүй болгох, дайсны хүчийг хоёр хувааснаар давшилтыг таслан зогсоох зорилготой байна.

Зөвхөн байлдааны ажиллагаа талаас харвал талууд паритет нөхцөлд буюу эн тэнцүү байдалд орсон бөгөөд энэ нөхцөл нь амьд хүчний хохирлыг нэмэгдүүлэхээс өөр бусад үр дүнг авчрахгүй байдалд орсон байна.

Алив улсын зэвсэгт хүчин нь өөрийн улсад улс төрийн шийдвэр гаргахад таатай нөхцөлийг үүсгэх үндсэн үүрэгтэй бөгөөд дээрх байлдааны өнгөрсөн болон одоогийн нөхцөл байдал талаас харвал байлдаанд оролцогч улсуудын зэвсэгт хүчнүүд үндсэн үүргээ биелүүлж дуусаагүй буюу байлдааны ажиллагаа 2026 он дуустал үргэлжлэх төлөвтэй байна. 2025 оноос цэргийн бүртгэлийг цахимжуулж төрийн үйлчилгээний системтэй холбож цахим хэлбэрээр цэргийн зарлан илгээх бэлтгэл ажлыг хангасан бөгөөд 2026 оны цэрэг татлага нь хүн амын дундаж давхарга буюу орос иргэдийг хамрахаар байна.

Мөн түүнчлэн бас нэг анхаарал татах үйл явдал 2024 оны 03 дугаар сард Москва хотын Крокус сити холл дахь террорист халдлага гарсанаар үндсэрхэг үзэлтэй бүлэглэл идэвхжиж Төв Ази гаралтай иргэдийг цэрэгт явуулах ажиллагаа эрчимжсэн боловч төдийлөн ахиц гараагүйн дээр Төв Азийн орнуудын чимээгүй дургүйцлийг хүргээд байгаа нь цаашид дотоод аюулгүй байдлын зарим асуудлыг хурцатгах нөхцлийг үүсгэж болзошгүй юм.

Ингээд ОХУ-ын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтийг ерөнхий зураглал байдлаар харвал:

Улсын төсвийн 1/3 нь аюулгүй байдлын тогтолцоонд зориулагдсан хийгээд холбогдох хууль эрхзүйн өөрчлөлтийг хуульчлан баталсан байна.

Дайны зардал, эдийн засгийн хориг арга хэмжээнээс хамаарсан жилийн валютын ханшны уналт нь 6% ба макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Төв банкны бодлогын хүү нь 14,25% байна. Мөн “Үндэсний баялгийн сан”-ийн хэмжээ нь ДНБ-ний 6%-тай тэнцэх хэмжээтэй гэсэн албан ёсны мэдээлэлтэй байгаа ч хатуу рублийн бодлого, импортын барааны зардлын үнийн өсөлт, нийлүүлэлтийн хугацаа сунасан, экспортын бүтээгдэхүүний борлуулалт түүний төлбөрийн асуудлууд хүндэрч байгаа нь Газпром, Роснефть зэрэг төсөв бүрдүүлэгч төрийн өмчит компаниудад татварын хөнгөлөлтийг хуульчлан олгосон байдал, мөн автомашин үйлдвэрлэл, мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хар төмөрлөг, олзворлох (нүүрс), барилгын болон тээврийн салбаруудын томоохон аж ахуй нэгжүүд нь Засгийн газраас санхүүгийн дэмжлэг хүссэн зэрэг байдал нь дээрх албан ёсны статистик дүн, мэдээ, мэдэгдлийн бодит бус байдлыг илэрхийлж байна гэж харж болохын зэрэгцээ тус улсын санхүүгийн чадавх шавхагдаж дуусах шатандаа орсныг 2026 он гарснаар суурь татвар, хураамжийг нэмэгдүүлсэн байдал зэрэг үйл явдлууд илтгэж байна.

Улс төр, нийгмийн байдал нь дээрх бодит эдийн засгийн байдлыг үгүйсгэхийн зэрэгцээ цэргийн зардлыг нэмэгдүүлэх (военное кейнсианство) замаар эдийн засгийн хиймэл өсөлтийг дөвийлгөн суртал ухуулгын цар хүрээг тэлэх болон гадаад мэдээллийн эх үүсвэрүүдийг хаах бодлогыг баримтлахын хажуугаар дотоодын аюулгүй байдлыг хангах байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж байна.

Дээрх нийгэм, эдийн засагт суурилсан дотоод бодлогыг харвал тус улс нь урт хугацааны дайнд шилжих зорилготой нь илт байна.

Олон улсын байдлаас харвал АНУ-ын зуучлал, шахалт бүхий хэлэлцээрийн ард Украин улсыг Европын Холбоо 2027 оныг дуустал санхүүжүүлэх төсвийг баталсан хийгээд, нөгөө талаас ОХУ-д БНХАУ-ын хязгаарлагдмал дэмжлэг үзүүлж байгаа олон улсын харилцаа тодорхойлж байна. Мөн үүний зэрэгцээ АНУ-ын Ойрх Дорнод, Өмнөд Америк болон Номхон далай дахь үйл ажиллагаа байдлыг улам ээдрээтэй болгохын зэрэгцээ ИБИНВУ-ын оролцоо бүхий далд үйл ажиллагаанууд нь ирээдүйн хэтийн төлөвийг өөрчлөх хүчин зүйл байх нөхцөлийг хадгалсаар байхаар байна.

Ингээд нэгтгэн дүгнэвэл тус дайны оролцогч талууд нь нийгэм, эдийн засаг, батлан хамгаалах салбараа дунд болон урт хугацааны дайны нөхцөлд байх тооцоо бүхий бодлогыг хэрэгжүүлж байгаа, нөгөө талаас дайны шууд бус оролцогч улсуудын бодлого болон байлдааны ажиллагааны байдлыг тооцвол Орос-Украины дайн 2026-2027 онуудад идэвхтэй үргэлжлэх бөгөөд хэрэв онцгой өөрчлөлт гарахгүй нөхцөл байдал хадгалагдвал 2030 онд бүрэн эсвэл хэсэгчлэн намжмал байдалд шилжих хэтийн төлөв ажиглагдаж байна.

Энэ дайн нь глобал орчинд нөлөө үзүүлж байгаа хоёр улсын хооронд өрнөж байгаа дайн ба бүс нутгийн хэмжээний дайн болоход тун бага зай үлдсэн гэдгийг тооцох нь зүйтэй бөгөөд бүс нутгийн дайны нөхцөлийг ОХУ бүх нийтийн дайчилгааг зарласнаар Беларусь, Польш болон Балтийн орнууд бүх нийтийн дайчилгаа зарлахад хүргэх нөхцөл бөгөөд энэ боломж хадгалагдсаар байна.

Хэрэв энэхүү дайн бүхий хурцадмал байдлын өрнөл ямар байхаас үл хамааран улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбаруудад түлхүү чиглэсэн улс орнуудын тагнуулын ажиллагаа өргөжих нөхцөл аль хэдийн бүрдсэн байдал нь өөр улс орнуудыг хамарсан цэрэг, байлдааны ажиллагаа тасралтгүй үргэлжлэх хандлагатай байна.

Цаашид олон улсын аюулгүй байдлын орчинд багагүй сорилтууд тасралтгүй гарч аж үйлдвэрийн түүхий эд, боловсруулалт, үйлдвэрлэлийн хэсгийг багтаасан хэлхээ аль нэг хүчний мэдэлд орох, хүнсний хомсдлоос үүдсэн хүнсний үнийн өсөлт нь эдийн засагт түлхүү нөлөөлөх чиг хандлагатай нилээдгүй он жилүүд хүн төрөлхтнийг хүлээж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. А.А.Шевченко. 2016. “Экономический кризис в россии.” *киберленинка*.
2. Е.Ф.Поддубская. 2024. “Один пояс-один путь” как внешнеполитический проект КНР.” *киберленинка* 59-60.
3. Мудрац, Александр. 2019. “История создания партии “Единая Россия”. *ТАСС*, 23 11.
4. *Независимая газета*. 2020. “Закончена десятилетка перевооружения.” 25 12.
5. С.М.Юн. б.д. “политика европейского союза в отношении соседних государств в 1990-е ГГ.: Развитие новых подходов.” 136-140.